



МОНГОЛБАНКНЫ МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ХОРООНЫ ОРОН ТООНЫ БУС ГИШҮҮНД НЭР ДЭВШИХ ТУХАЙ ХҮСЭЛТ

Товч удирдамж: Нэр дэвших тухай хүсэлт гаргахдаа энэхүү загварт асуусан асуулт, шаардсан мэдээлэл бүрийн доор /ард/ хариултаа үнэн зөв бичнэ. Компьютерын програм ашиглаж бичсэн хүсэлтийг цаасаар хэвлэж гарын үсэг зурах бөгөөд уг эх хувь, түүний хавсралт мөн Word-ын файлыг цахим шуудангаар тус тус Байнгын хороонд явуулна.

Хуульд заасан шаардлага: Төв банк /Монголбанк/-ны тухай хуулийн 27³ дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан шаардлагыг хангасан байна. Үүнд:

2.Орон тооны бус гишүүн дараахь шалгуурыг хангасан байна:

1/банк, санхүү, эдийн засгийн чиглэлийн их дээд сургууль, судалгаа, эрдэм шинжилгээний байгууллагад мэргэжлээрээ 10-аас дээш жил, үүний таваас доошгүй жилд макро эдийн засгийн бодлого, судалгаа шинжилгээний чиглэлээр ажилласан туршлагатай;

2/Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа банкны эрх бүхий албан тушаалтан, банкны нөлөө бүхий хувьцаа эзэмшигч, тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээд, холбогдох этгээд биш;

3/ашиг сонирхлын зөрчилгүй.

НЭГ. НЭР ДЭВШИГЧИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА, НИЙТЛЭГ ШААРДЛАГА

1.1	Эцэг/эхийн нэр: Батбаатар Ургийн овог: Нэр: Мөнхзаяа Хүйс: Эм Төрсөн он: 1984 Төрсөн газар: Завхан аймаг, Тосонцэнгэл сум Иргэний харьяалал: Монгол Одоо оршин суугаа аймаг /нийслэл, сум/ дүүрэг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1 хороо
1.2	Нэр дэвших тухай хүсэлт гаргаж буй албан тушаал МОНГОЛБАНКНЫ МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ХОРООНЫ ОРОН ТООНЫ БУС ГИШҮҮНД
1.3	Иргэний харьяалал Монгол Улсын иргэн мөн эсэх <i>/тийм, эсхүл үгүй гэж бичих. Үгүй бол Монгол Улсаас өөр улсын иргэний харьяалалтай байсан эсэхийг тодорхой бичих/</i>

	Тийм
1.4	<p>Боловсрол Дээд боловсрол эзэмшсэн сургууль тус бүрийг сүүлд төгссөн сургуулиас нь эхлэн он дарааллаар жагсааж, холбогдох нотлох баримтыг хавсаргана. <i>/сургууль тус бүрд суралцсан хугацаа, авсан зэрэг, огноог бичнэ/</i> 1. Австралийн Монашийн Их сургууль, 1.5 жил, Банк санхүүгийн мастер, 2019-2020 2. СЭЗДС, 4 жил, Бизнесийн удирдлагын ухааны доктор, 2009-2013 3. СЭЗДС, 2 жил, Бизнесийн удирдлагын мастер, 2006-2008 4. СЭЗДС, 4 жил, Бизнесийн удирдлагын бакалавр, 2001-2005</p>
1.5	<p>Боловсролын болон шинжлэх ухааны докторын зэрэг Бизнесийн удирдлагын ухааны доктор Диссертацийн сэдэв: Санхүүгийн хямралын үе дэх арилжааны банкны эрсдэлийн удирдлагын тогтолцоог боловсронгуй болгох нь</p>
1.6	<p>Эрүүл мэнд Сэтгэцийн өвчин, эмгэгтэй эсэхийг тодорхойлсон нотлох баримтыг жагсааж, хавсаргана.</p> <p>Эрүүл</p>
1.7	<p>Эрхэлсэн ажил Их, дээд сургууль төгссөнөөс хойш эрхэлсэн ажлыг тодорхойлон бичнэ. Банк, санхүү, эдийн засгийн чиглэлийн их дээд сургууль, судалгаа, эрдэм шинжилгээний байгууллагад мэргэжлээрээ 10-аас дээш жил, үүний таваас доошгүй жилд макро эдийн засгийн бодлого, судалгаа шинжилгээний чиглэлээр ажилласан болохыг нотлох баримтыг хавсаргана. Ажилласан байгууллагыг хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар жагсаах бөгөөд ажил олгогч <i>/эсхүл, удирдах албан тушаалтан/-ийн нэр, хаяг, утасны дугаар, цахим шуудангийн хаяг, цахим хуудас болон ажлын байрны нэрийг бичнэ.</i></p> <p>1. Санхүү эдийн засгийн их сургууль</p> <ul style="list-style-type: none"> • 2021 - Одоог хүртэл, Бакалаврын сургалт, судалгаа хариуцсан проректор • 2018-2019, Санхүүгийн удирдлагын тэнхим, Дэд профессор • 2015-2018, Санхүүгийн удирдлагын тэнхим, Эрхлэгч • 2005-2015, Санхүүгийн удирдлагын тэнхим, Багш <p>Б.Мөнхбаяр, Санхүү эдийн засгийн их сургуулийн ректор, 9999-1119, munkhbayar.b@ufe.edu.mn, www.ufe.edu.mn</p>

1.8	<p>Ашиг сонирхлын зөрчил Хуулийн этгээдийн хувьцаа эзэмшдэг, аж ахуйн үйл ажиллагаа эрхэлдэг эсэх, Банк бус санхүүгийн байгууллага, банкны хувьцаа эзэмшдэг эсэхийг бичих. <i>/тийм, эсхүл үгүй гэж бичих. Тийм гэж хариулсан бол холбогдох баримт бичгийн хуулбарыг хавсаргах, ямар хувьцаа, аж ахуйн үйл ажиллагааг ямар хугацаанд эзэмшиж, эрхэлж байгаа, эсхүл эзэмшиж, эрхэлж байсан талаараа хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичих/</i></p> <p>Үгүй</p>
1.9	<p>Улс төрийн болон намын удирдах, гүйцэтгэх албан тушаал Сүүлийн таван жил улс төрийн албан тушаал болон улс төрийн намын удирдах, гүйцэтгэх албан тушаал эрхэлж байсан эсэхийг бичих. <i>/тийм, эсхүл үгүй гэж бичих. Тийм гэж хариулсан бол холбогдох баримт бичгийн хуулбарыг хавсаргах, ямар албан тушаалыг ямар хугацаанд эрхэлж байгаа, эсхүл эрхэлж байсан талаар хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичих/.</i></p> <p>Үгүй</p>
1.10	<p>Мэргэжлийн холбоо, байгууллагын гишүүнчлэлийн талаар Сүүлийн таван жил ямар мэргэжлийн холбоо, байгууллагад удирдах, гүйцэтгэх албан тушаал эрхэлж байсан, гишүүнчлэлийн талаар бичих. <i>/тийм, эсхүл үгүй гэж бичих. Тийм гэж хариулсан бол холбогдох баримт бичгийн хуулбарыг хавсаргах, ямар албан тушаал, чиг үүрэг гүйцэтгэж байсан талаар хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичих/</i></p> <ol style="list-style-type: none"> 1. 2024 оноос, Project management institution, Гишүүн 2. 2023 оноос, Боловсролын магадлан итгэмжлэлийн үндэсний зөвлөлийн “Бизнес, удирдлагын чиглэлээрх мэргэжлийн зөвлөл”, Гишүүн 3. 2023 оноос, Санхүүгийн зохицуулах хорооны “Мөнгөн зээлийн үйл ажиллагааны бодлогын зөвлөл”, Гишүүн 4. 2023 оноос, МҮХАҮТ-ийн дэргэдэх Ёс зүйн төв, Сургагч багш 5. 2022 оноос, International compliance association, Гишүүн 6. 2020-2022, Financial Services Institute of Australia, Гишүүн 7. 2014-одоог хүртэл, Үнэт Цаасны Арилжаа Эрхлэх Төв, Сургагч багш 8. 2018-2019, Банк Санхүүгийн Академи ГҮТББ, Удирдах зөвлөлийн дэргэдэх “Эрх олгох зөвлөл”, гишүүн 9. 2016-2017, Ерөнхий Сайдын Эдийн Засгийн Зөвлөл, Гишүүн 10. 2013-2016, Компанийн Засаглал Хөгжүүлэх Төв, Сургагч багш
1.11	<p>Мэргэжлийн ёс зүйн талаар Мэргэжлийн ёс зүйн зөрчил гаргаж байсан эсэх. <i>/тийм эсхүл үгүй гэж бичих. Тийм гэж хариулсан бол хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичих/.</i></p> <p>Үгүй</p>

1.12 Хэрэв доор дурдсан мэдээлэл нэр дэвшигчид байгаа бол

Өөрийн боловсруулсан, хянасан судалгааны ажил, ном, өгүүлэл, тайлан, шийдвэр, зөвлөмж зэрэг аливаа хэлбэрээр хэвлүүлсэн материал байгаа бол гарчиг, хэвлэсэн газар, огноог бичнэ.

Ном, судалгааны тайлан

1. Б.Мөнхзаяа ба бусад. (2024). Уул уурхайн салбарын гадаадын шууд хөрөнгө оруулалтын Монгол улсын нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөө. Улаанбаатар, Монгол.
2. Б.Мөнхзаяа ба бусад. (2024). Орон сууцны санхүүжилтийг боловсронгуй болгох арга зам. Улаанбаатар, Монгол.
3. Б.Мөнхзаяа ба бусад. (2023). Санхүүгийн зохицуулалттай салбарууд дахь комплайнсын хяналтын тогтолцооны өнөөгийн байдал. Улаанбаатар, Монгол.
4. Б.Мөнхзаяа ба бусад. (2023). Бизнесийн ёс зүй ба комплаенс. Улаанбаатар, Монгол.
5. Б.Мөнхзаяа. (2014). Санхүүгийн хямралын үе дэх арилжааны банкны эрсдэлийн менежментийн аргазүй. Улаанбаатар, Монгол.
6. Б.Мөнхзаяа. (2013). Санхүүгийн байгууллагын эрсдэлийн менежмент. Улаанбаатар, Монгол.
7. Б.Мөнхзаяа. (2011). Санхүүгийн байгууллагын эрсдэл. Улаанбаатар, Монгол.
8. Б.Мөнхзаяа. (2009). Санхүүгийн байгууллагын эрсдэл. Улаанбаатар, Монгол.
9. Б.Мөнхзаяа. (2006). Санхүү - Finance. Улаанбаатар, Монгол.

Эрдэм шинжилгээний хурал, илтгэл

1. Б.Мөнхзаяа. (2021.12.17). Төв банкны хараат бус байдал ба санхүүгийн тогтвортой байдал. Төвбанкны хараат бус байдал эрдэм шинжилгээний бага хурлын эмхэтгэл. Улаанбаатар.
2. Б.Мөнхзаяа. (2018.05.25). Санхүүгийн хямралын үед хөрөнгө оруулагчдын эрсдэлийг бууруулах арга зам. Монгол Улсын Санхүүгийн зах зээл-Хөгжлийн гарц сэдэвт эрдэм шинжилгээний бага хурлын эмхэтгэл. Улаанбаатар.
3. Б.Мөнхзаяа. (2017.04.06). Зээлийн хүүг бууруулах үндэсний стратеги. СЭЗИС-ийн 10 дахь удаагийн Эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. Улаанбаатар.
4. Б.Мөнхзаяа. (2016.12.14). Монголын улсын санхүүгийн системийн аюулгүй байдал, тулгамдаж буй асуудлууд. “Аюулгүй байдлын онол, практикийн тулгамдсан асуудлууд” эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. Улаанбаатар.
5. Б.Мөнхзаяа. (2016.06.05). Монголын санхүүгийн системд үүсч болзошгүй эрсдэлүүд. СЭЗДС-ийн ЭШХ-ийн бүрэн эмхэтгэл №3, (хуудсд. 15-29). Улаанбаатар.
6. Б.Мөнхзаяа. (2013.06.01). Санхүүгийн хямралын үе дэх арилжааны банкны эрсдэлийн менежментийг боловсронгуй болгох аргазүй.

СЭЗДС-ийн ЭШХ-ийн бүрэн эмхэтгэл №3, (хуудсд. 15-29).
Улаанбаатар.

7. Б.Мөнхзаяа. (2012.10.26). Арилжааны банкны эрсдэлийн нэгдсэн үнэлгээ, түүнийг шийдвэр гаргалтанд ашиглах нь. “Хүрэл тогоот – 2012” залуу судлаачдийн эрдэм шинжилгээний хурлын бүрэн эмхэтгэл, (хуудсд. 213-220). Улаанбаатар.
8. Б.Мөнхзаяа. (2012.06.09). Монголын эдийн засгийн мөчлөгийн шинжилгээ ба индикатор. МУИС – Орхон сугууль, “Монгол улсын эдийн засгийн чиг хөгжлийн” эрдэм шинжилгээний хурлын бүрэн эмхэтгэл, (хуудсд. 21-36). Улаанбаатар.
9. Б.Мөнхзаяа. (2012.05.09). Хямралын үе дэх арилжааны банкны шийдвэр гаргалтын арга зүйг боловсронгуй болгох нь. "Монгол улсын эдийн засаг, бизнесийн судалгаа" эрдэм шинжилгээний бичиг № 361, (хуудсд. 297-313). Улаанбаатар.
10. Б.Мөнхзаяа. (2011.10.08). Монголын банкны салбар: Хямрал ба сургамж. “Хүрэл тогоот – 2011” залуу судлаачдийн эрдэм шинжилгээний хурлын бүрэн эмхэтгэл, (хуудсд. 113-119).
11. Б.Мөнхзаяа. (2011.10.08). Монголын санхүүгийн салбарын тогтвортой байдлын шинжилгээ ба үнэлгээ. “Хүрэл тогоот – 2011” залуу судлаачдийн эрдэм шинжилгээний хурлын бүрэн эмхэтгэл, (хуудсд. 99-112). Улаанбаатар.
12. Б.Мөнхзаяа. (2011.09.19). Банкны секторын хөгжил ба эдийн засгийн өсөлтийн хамаарлын шинжилгээ. “Монгол улсын бүртгэл санхүүгийн тэргүүний ажилтны 5-р зөвөлгөөн” хурлын бүрэн эмхэтгэл, (хуудсд. 231-233). Улаанбаатар.
13. Б.Мөнхзаяа. (2011.06.03). Монголын санхүүгийн салбарын тогтвортой байдлын шинжилгээ ба үнэлгээ. “Монгол улсын үйлдвэрлэлийн хөгжил ба эдийн засгийн өсөлт” олон улсын эрдэм шинжилгээний хурлын бүрэн эмхэтгэл, (хуудсд. 57-71). Улаанбаатар.
14. Б.Мөнхзаяа. (2011.04.29). Санхүүгийн хямралын шалтгаан ба санхүүгийн тогтвортой байдал (онолын судалгаа). ШУТИС-ийн Эрдэм шинжилгээний бичиг 2/118, (хуудсд. 221-230). Улаанбаатар.
15. Б.Мөнхзаяа. (2011.04.29). Монголын санхүүгийн салбарын тогтвортой байдлын шинжилгээ. ШУТИС-ийн Эрдэм шинжилгээний бичиг 2/118, (хуудсд. 244-253). Улаанбаатар.
16. Б.Мөнхзаяа. (2011.04.11). Монголын санхүүгийн салбарын тогтвортой байдлын шинжилгээ. СЭЗДС-ийн ЭШХ-ийн бүрэн эмхэтгэл, (хуудсд. 70-80). Улаанбаатар.
17. Б.Мөнхзаяа. (2011.04.11). Санхүүгийн хямралын шалтгаан ба санхүүгийн тогтвортой байдал (онолын судалгаа). СЭЗДС-ийн ЭШХ-ийн бүрэн эмхэтгэл №2, (хуудсд. 91-101). Улаанбаатар.
18. Б.Мөнхзаяа. (2010.04). Хадгаламжид баталгаа гаргах уу эсвэл даатгах уу? СЭЗДС-ийн Багш нарын ЭШ-ний бага хурлын эмхэтгэл №1, (хуудсд. 83-94). Улаанбаатар.

Эрдэм шинжилгээний өгүүлэл

1. Б.Мөнхзаяа. (2020). Зээлийн хүүний дарамтыг бууруулах, зээлийн хүүнд хязгаар тавих хоёр адил ойлголт уу? Financial inclusion magazine 01/20.
2. Б.Мөнхзаяа. (2016.02). Эрсдэлийг удирдах аргагүй. Хэрэглээний стандарт онол, аргагүй, судалгааны чөлөөт хэвлэл, 30-32.
3. Б.Мөнхзаяа. (2016.01). Эрсдэлийг үнэлэх аргагүй. Хэрэглээний стандарт онол, аргагүй, судалгааны чөлөөт хэвлэл, 26-28.
4. Б.Мөнхзаяа. (2015.10.22). Гадаад өрийн дарамт, эдийн засагт учирч болох эрсдэлүүд, бодлогын зөвлөмж. Монголбанкны судалгааны товхимол-10, 799-874.
<https://www.mongolbank.mn/documents/tovhimol/group10/01.pdf>-ээс Гаргасан
5. Б.Мөнхзаяа. (2015.06.29). Санхүүгийн хямралын үе дэх арилжааны банкны эрсдэлийн менежментийг боловсронгуй болгох аргагүй. Монголбанк ЭШ онол, практикийн бүтээлүүдийн товхимол, 201-232.
6. Б.Мөнхзаяа. (2015.01). Эрсдэлийн төрөл, ангилал хийх аргагүй. Хэрэглээний стандарт онол, аргагүй, судалгааны чөлөөт хэвлэл, 26-28.
7. Б.Мөнхзаяа. (2014.08). Эрсдэлийг тодорхойлох аргагүй. Хэрэглээний стандарт онол, аргагүй, судалгааны чөлөөт хэвлэл, 30-32.
8. Б.Мөнхзаяа. (2014.04). Эрсдэлийн менежментийн үүсэл хөгжил. Хэрэглээний стандарт онол, аргагүй, судалгааны чөлөөт хэвлэл.
9. Б.Мөнхзаяа. (2014.02.07). Leading indicator for business cycle: In Mongolian Cases. International journal of Management, 1, 1-21.
10. Б.Мөнхзаяа. (2012 оны 6). Хямралыг урьдчилан таамаглах ба түрүүлэгч индикатор. Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институт, №02(12), 28-32.
11. Б.Мөнхзаяа. (2012 оны 6). Хямралыг урьдчилан таамаглах ба тодорхой бус орчин нөхцөлд шийдвэрийг хэрхэн гаргах вэ? Менежер, 06/2012 №13(31), 37-42.
12. Б.Мөнхзаяа. (2010 оны 12). Creation on an effective deposit insurance system in Mongolia. Logos Management Review Volume 8 No. 3, 87-102.
13. Б.Мөнхзаяа. (2008). Арилжааны банкны валютын ханшийн эрсдэлийн удирдлагыг боловсронгуй болгох зарим асуудал. Мастерын дипломын ажил, СЭЗДС.
14. Б.Мөнхзаяа. (2005). Зах зээлийн эрсдэл тооцох аргачлал. Бакалаврын дипломын ажил, СЭЗДС.

-Өөрийн харьяалагддаг байгууллагын нэрийн өмнөөс бэлдсэн, эсхүл бэлдэхэд оролцсон аливаа хууль тогтоомж, дүрэм, журам, шийдвэр, тайлан, зөвлөмж болон бусад материал байгаа бол түүнийг хэвлэсэн байгууллагын нэр, хаяг, огноо, гол агуулгыг бичнэ.

1. СЭЗИС ба МИК (2024). Орон сууцны санхүүжилтийн өнөөгийн байдал, боловсронгуй болгох арга зам. Улаанбаатар, Монгол. Орон сууцны худалдан авах чадвар болон орон сууцны санхүүжилтийн тогтолцоог

2. СЗХ (2024) “Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдээс олгох зээлийн хүүгийн дээд хэмжээ”-г тогтоох тухай тогтоол гаргахад үндэслэл болох судалгааг хийсэн.
3. Б.Мөнхзаяа ба бусад. (2018.12.21). Гадаадын банкны санхүүгийн зах зээлд үзүүлэх нөлөө, нэвтрүүлснээр тохиолдох эрсдэлийг бууруулах зөвлөмж. Монголбанкны судалгааны товхимол 2018 он, 222-289.
<https://www.mongolbank.mn/documents/tovhimol/group13/01.pdf>-ээс Гаргасан

-Сүүлийн таван жилийн хугацаанд хэлэлцүүлсэн лекц, илтгэл, нээлтийн үг зэрэг илтгэл, ярианы товч утга, огноо, газар, танилцах арга замыг бичнэ. Тухайн илтгэл, ярианы хуулбарыг хийх боломжгүй бол түүнийг зохион байгуулсан байгууллагын нэр, хаяг, илтгэл, ярианы огноо, товч утгыг бичнэ.

1. СЭЗИС-д 2021 оноос хойш Дэлхийн ёс зүйн өдрийг санаачлан тэмдэглэж, хэлэлцүүлэг, эсээ бичлэгийн уралдааны зарлан зохион байгуулж байна.
[Мэргэжлийн ёс зүйн ач холбогдол | Global Ethics Day 2023 | Part 1](#)
2. Ёс зүйн чиглэлийн эсээ бичлэгийн уралдааныг жил бүр уламжлал болгон зохион байгуулж байна.
[“Мэргэжлийн ёс зүйн ач холбогдол” эсээ бичлэгийн уралдаанд оролцохыг урьж байна](#)
[Онцлох зочин СЭЗИС-ийн баклаврын сургалт, судалгаа хариуцсан проректор, доктор Б.Мөнхзаяа](#)
3. СЭЗИС-д 2022 оноос хойш Тогтвортой хөгжлийн зорилгуудыг дэмжих Студент лед төслийн уралдааныг санаачлан зохион байгуулж байна. 2024 онд нийт их дээд сургуулиудын оюутнууд оролцох боломжийг олгон 10 сая төгрөгийн шагналын сантай зохион байгуулсан.
[\(332\) UFE Volunteer Fair 2023 | - YouTube](#)
4. Б.Мөнхзаяа ба бусад. (2018.12.21). Гадаадын банкны санхүүгийн зах зээлд үзүүлэх нөлөө, нэвтрүүлснээр тохиолдох эрсдэлийг бууруулах зөвлөмж. Монголбанкны судалгааны товхимол 2018 он, 222-289.
<https://www.mongolbank.mn/documents/tovhimol/group13/01.pdf>-ээс Гаргасан

-Сүүлийн таван жилийн хугацаанд хэвлэл, мэдээллийн хэрэгсэлд өгсөн ярилцлага, нийтлэлийг хамгийн сүүлийнхээс нь эхлэн жагсааж бичнэ. Ярилцлага, нийтлэлүүдийн огноог зааж, боломжтой бол ярилцлагын тэмдэглэл, дүрс бичлэг, нийтлэлийг хуулбарлан өгнө.

1. Б.Мөнхзаяа (2024 оны 11 29) "Ипотекийн зээлээ ялгаатай хэрэгжүүлбэл үр дүнтэй" (Зууны мэдээ сонин) [Б.Мөнхзаяа: Ипотекийн зээлээ ялгаатай хэрэгжүүлбэл үр дүнтэй](#)
2. Б.Мөнхзаяа (2024 оны 11 15) "Ипотекийн зээлийн хөтөлбөр анхандаа орлого багатай, зорилтот бүлэгт чиглэж байсан ч сүүлдээ чинээлэг хүмүүсийн дахин байртай болох боломжийг бүрдүүлдэг хэрэгсэл болж хувирсан" (Bloomberg TV Mongolia ярилцагч)
<https://fb.watch/wrFRoJ4enT/>

3. Б.Мөнхзаяа. (2024 оны 10 09). Дэлхийн Ёс Зүйн өдөр (МҮОНТ Онцлох зочин) [Онцлох зочин СЭЗИС-ийн баклаврын сургалт, судалгаа хариуцсан проректор, доктор Б.Мөнхзаяа](#)
4. Б.Мөнхзаяа. (2023 оны 4 23). Бакалавр 2.0. (ufe.edu.mn, Ярилцагч) <https://www.youtube.com/watch?v=Wxm6JRTx6o&list=PLqnoOV7X-g8eQFOuBUtdH4aB-Ptea-Qlf&index=2>
5. Б.Мөнхзаяа. (2022 оны 6 23). Бакалавр 2.0. (gogo.mn, Ярилцагч) <https://gogo.mn/r/vv24y>
6. Б.Мөнхзаяа. (2021 оны 12 30). Төв банкны хараат бус байдал. (Bloomberg, Ярилцагч) <https://www.youtube.com/watch?v=mrWaUp3NnyI>
7. Б.Мөнхзаяа. (2021 оны 11 24). Төсвийн зардал. (Bloomberg, Ярилцагч) <https://www.youtube.com/watch?v=PctIXUIJ6jY>
8. Б.Мөнхзаяа. (2021 оны 11 21). “Монголбанк нь улс төрөөс, Монгол Улс нь БНХАУ-аас хараат болчихоод байна” (iToim.mn) [Б.Мөнхзаяа: Монголбанк нь улс төрөөс, Монгол Улс нь БНХАУ-аас хараат болчихоод байна](#)
9. Б.Мөнхзаяа. (2018 оны 11 18). “Санхүүгийн хүртээмж”, [СЭЗИС-ийн СУТ-ийн дэд профессор, доктор Б.Мөнхзаяа МҮОНТВ-ийн зочны цагт оролцлоо](#)

/Жич: Дээр дурдсан материал тус бүрээс нэгийг хавсаргах бөгөөд боломжтой бол цахимаар үзэх линкийг тусгана/

ХОЁР. ХИЙХ АЖИЛ, НЭР ДЭВШСЭН ҮНДЭСЛЭЛЭЭ БИЧСЭН ТАЙЛБАР

- 2.1** Тухайн албан тушаалд томилогдвол хийх ажил, уг албан тушаалд нэр дэвшсэн үндэслэлээ тайлбарлаж тодорхой, ойлгомжтой бичнэ.
/500-1000 үгэнд багтаана/.
- Монголбанкны мөнгөний бодлогын зөвлөлийн орон тооны бус гишүүнээр нэр дэвших үндэслэл:**
- Монгол Улсын эдийн засгийн өсөлтийг тогтвортой хангаж, макро эдийн засгийн тогтвортой байдлыг бэхжүүлэхэд мөнгөний бодлогын оновчтой шийдвэр, үр дүнтэй хэрэгжилт чухал үүрэгтэй. Би энэхүү албан тушаалд нэр дэвшихдээ өөрийн мэдлэг, ур чадвар, туршлагаа Монголбанкны мөнгөний бодлогын зөвлөлийн үйл ажиллагаанд хувь нэмэр оруулахад зориулна гэсэн чин хүсэл эрмэлзэлтэй байна.
- | Эдийн | засгийн | бодлогын | туршлага |
|--|----------------|-----------------|-----------------|
| Миний бие Монгол банк, Санхүүгийн зохицуулах хороо, Монголын ипотекийн корпорацитай хамтран эдийн засгийн бодлогын чиглэлээр хамтарсан судалгааны ажлууд хийж байсан туршлагатай, мөн 2022 онд Төв банкны хараат бус байдлын чиглэлээр эрдэм шинжилгээний ажил хийн, төв банкнаас зохион байгуулсан хуралд судалгааны ажлаа танилцуулж байсан. 2013 онд докторын судалгааны ажил хийхээ хямралын үед банкны салбарын эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх зарчмуудыг судалж байсан ба эдийн засгийн мөчлөгийг түрүүлэгч индикаторуудын тусламжтай тодорхойлох арга зүйг боловсруулж байсан. 2014 онд Монгол банкны 90 жилийн ойн эрдэм шинжилгээний хуралд энэ сэдвээр | | | |

оролцож дэд байрын шагнал хүртэж байсан. Нийт 19 жилийн хугацаанд дээд боловсролын байгууллагад ажиллахдаа эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг тасралтгүй хийж, Монгол Улсын эдийн засгийн онцлогийг гүнзгий ойлгодог бөгөөд гадаад, дотоод зах зээлийн өөрчлөлт, нөлөөллийг бодлогоор зохицуулах арга барилд тасралтгүй суралцаж, түүнийгээ сургалт, судалгааны ажилдаа ашиглаж байна. Ингэснээр бодлогын шийдвэр гаргах, санхүүгийн тогтвортой байдлыг хангахад бодитой хувь нэмэр оруулах боломжтой гэж үзэж байна..

Мэдлэг, боловсрол

Миний бие банк санхүүгийн бакалаврын зэргийг 2005 онд эзэмшсэн ба 2013 онд докторын зэрэг хамгаалсан. Олон улсад банк санхүүгийн салбарт эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлдэг туршлагыг судлах зорилгоор дэлхийн топ 100 сургуулийн нэг Австрали улсын Монашын их сургууль дахин банк, санхүүгийн мастерын зэрэг эзэмшсэн. Би санхүү, эдийн засгийн чиглэлээр сургалт судалгааны ажил хийхээс гадна судалгааны төсөлд оролцож, дүн шинжилгээ хийх, зөвлөмж боловсруулах чадвараа нэмэгдүүлж байна.

Шударга ёс, ёс зүйн баримтлал

Монгол Улсын иргэний хувьд шударга ёсыг дээдлэх, аливаа ажлыг ёс зүйтэй, хариуцлагатайгаар гүйцэтгэхийг үргэлж эрхэмлэж ирсэн. Мөнгөний бодлогын шийдвэрүүд нь олон нийтийн итгэл хүлээсэн байх ёстой бөгөөд энэ чиглэлд миний ёс зүйн өндөр үнэлэмж хэрэгтэй гэж үзэж байна. Мөн Австрали улсад суралцаад төгсөж ирээд Дэлхийн ёс зүйн өдөр, Тогтвортой хөгжлийн зорилгыг дэмжих төслийн уралдаан, сайн удын үзэсгэлэнг жил бүр тэмдэглэн өнгөрүүлэх санаачилга гарган бүх их дээд сургуулийн оюутнуудад мэдлэг, ойлголт өгөх ажлыг жил бүр уламжлал болгон зохион байгуулж байна. 2024 оны 10 сард болсон Ёс зүйтэй шийдвэр гаргалт сэдэвт хэлэлцүүлэгт Монголбанкны төлөөллийг урьж оролцуулсан.

Судалгааны чадвар ба дата дүн шинжилгээ

Мөнгөний бодлогын оновчтой шийдвэр гаргахын тулд зах зээлийн өөрчлөлт, гадаад, дотоодын макро эдийн засгийн үзүүлэлтүүдэд дүн шинжилгээ хийх шаардлагатай. Энэ чиглэлд миний эзэмшсэн арга зүй, судалгааны ур чадвар өндөр үр дүн авчирна гэдэгт итгэлтэй байна.

Томилогдвол хийх ажлын төлөвлөгөө

- Мөнгөний бодлогын шийдвэрийг шинжлэх ухааны үндэслэлтэй гаргах, үндэсний онцлогт тохируулан хэрэгжүүлэхэд оролцох.
- Инфляцын түвшинг тогтворжуулах, ажлын байрыг нэмэгдүүлэх, санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг бэхжүүлэхэд чиглэсэн бодлогын шийдвэрт анхаарал хандуулах.
- Дотоодын эдийн засгийн болон олон улсын санхүүгийн орчны өөрчлөлтийг оновчтой үнэлж, цаг алдалгүй зохицуулалт хийхэд дэмжлэг үзүүлэх.
- Олон нийтийн оролцоог дэмжсэн ил тод бодлогыг хэрэгжүүлэх, эдийн засгийн мэдлэгийг нэмэгдүүлэх зорилгоор сургалт, мэдээллийн ажлуудыг өрнүүлэх.
- Эдийн засгийн бодлогыг байгаль орчны тогтвортой хөгжил, нийгмийн сайн сайхныг хангах чиглэлд уялдуулах.

Монголбанкны мөнгөний бодлогын зөвлөлийн орон тооны бус гишүүнээр томилогдвол миний мэдлэг, туршлага, ёс зүй нь Монгол Улсын эдийн засгийн хөгжлийг дэмжсэн, иргэдийн итгэлийг хүлээсэн мөнгөний бодлогын шийдвэр гаргах үйл явцад хувь нэмэр оруулахад анхаарч ажиллах болно.

